

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ 2018 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол мэдээлэл

Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэст иргэд, хуулийн этгээдээс 764 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 319 буюу 41,7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 445 буюу 57.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.


1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Говьсүмбэр аймагт 2018 онд 176 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 5 буюу 2,9 хувиар өссөн байна.

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

№	Сум	2017 оны эхний 12 сар	2018 оны эхний 12 сар	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянтал сум	17	19	2	11.8%
2	Сүмбэр сум	134	131	-3	-2.2%
3	Шивээговь сум	20	21	1	5%

1.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



- хүнд гэмт хэрэг 29 бүртгэгдсэн нь 7 –оор буюу 31,8 хувиар ,
- хөнгөн гэмт хэрэг 147 бүртгэгдсэн нь 31-ээр буюу 24.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Жич: 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулинд хүндэвтэр болон онц хүнд гэмт хэргийн ангилал хасагдсан болно.

1.5 Бүртгэгдсэн тодорхой төрлийн гэмт хэрэг /ЭХ-ийн бүлгээр/

№	Гэмт хэргийн төрөл	2017 оны эхний 12 сар	2018 оны эхний 12 сар	Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь
1	Хүний амьд явах эрхийн эсрэг/10.1-10.6/	2	3	1	50
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11-7/	82	91	9	11
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /12.1-12.5/	4	10	6	2.6 дахин
4	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17.1-17.2/	56	52	-4	-7
5	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг /20.1-20.6, 20.16	4	2	-2	-50
6	Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /27.1-27.11/	20	11	-9	-45
7	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, /24.1-24.9	0	1	1 нэгж	1 нэгж
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг/21.1-21-14/	1	0	-1	-1 нэгж
9	Авилгын гэмт хэрэг/22.1-22.12/	0	6	6 нэгж	6 нэгж
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг/23.1-23.7/	2	0	-2	-2 нэгж

1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг



1.7 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Үйлдэгдсэн газар	Хэргийн тоо	Нийт хэрэгт эзлэх хувь
Гэр, орон сууц	61	34,6
Гудамж талбай, олон нийтийн газар	46	26
Байгууллага, аж ахуйн нэгж	24	13,6
Бусад газар	34	19,3
Авто зам	11	6,2

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2018 оны эхний 12 сарын байдлаар гэмт хэргийн илрүүлэлт 62,6 хувьтай байгаа нь өмнөх мөн үеийнхээс -2,6 нэгжээр буюу -4 хувиар буурсан байна.

2.2 Илрээгүй хэрэг /хэрэг бүртгэлтийн хэрэг/

2018 оны эхний 12 сарын байдлаар хэрэг бүртгэлт /эзэн холбогдогч нь тогтоогдоогүй/-ийн 171 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 59 буюу 52,7 хувь өсч, үүнээс 107 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 34-өөр буюу 46,5 хувь өссөн байна. Илрээгүй хэрэг 64 байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 124 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66 буюу 34,7 хувиар буурсан байна.

Үүнээс 18 буюу 14,5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 35,7 хувь буурсан бол 106 буюу 60,2 хувийг эрэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 56-аар буюу 32 хувь буурсан мөн насанд хүрээгүй этгээд 6 буюу 3,4 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогсдын нас, нийгмийн байдал




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Гэмт хэргийн улмаас

5 хүн нас барж, 107 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 4 буюу 44,4 хувь, гэмтсэн хүн 20 буюу 15,7 хувь тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 548,9 сая төгрөгийн хохирлын 290,8 буюу 53 хувийг нөхөн төлүүлж, 20.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал



Тав. Зөрчил

5.1 Зөрчлийн тоо, шийдвэрлэлт

Нийт 18779 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1591 буюу 9,3 хувь өссөн үзүүлэлттэй байна. Ердийн журмаар 18096 иргэнийг 483952.3 сая.төг-өөр, хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээж 361 иргэн, 9 хуулийн этгээдийг 106085,0 сая.төг-өөр торгож, 108 иргэнийг баривчлуулж, 158 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасчээ.

Зөрчил үйлдэгдсэн өдрөөр харуулбал: Даваа гарагт 3211, Мягмар гарагт 2916, Лхагва гарагт 2856, Пүрэв гарагт 2563, Баасан гарагт 2460, Бямба гарагт 2224, Ням гарагт 2549 зөрчил бүртгэгдсэнээс үзэхэд Даваа, Мягмар, Ням гарагуудад дийлэнх зөрчил үйлдэгдэж байна.

Зөрчил үйлдэгдсэн газар, цаг хугацаа: Өглөөний 06-12 цагийн үед 3112, 13-18 цагийн үед 8571, 19-24 цагийн үед 6062, 01-05 цагийн үед 1034 зөрчил тус тус бүртгэгдсэн байна. Үүнээс үзэхэд 13-24 цагийн үед дийлэнх зөрчил үйлдэгдэж байна.

Зөрчил үйлдэгдсэн газраар нь авч үзвэл: Гэр орон сууцанд 66, олон нийтийн газар-103, гудамж талбайд 125, төрийн байгууллагад 14, аж ахуйн нэгжид-14, авто замд 329, бусад газар 32 зөрчил үйлдэгджээ. Гудамж талбай, олон нийтийн газарт дийлэнх зөрчил үйлдэгджээ.

Зөрчил үйлдэгдсэн онцлогоор нь: Согтуугаар үйлдсэн-328, эмэгтэй хүн оролцсон-47, хүүхэд оролцсон-5, гадаадын иргэн-2, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил-31 тус тус бүртгэгдсэн.

Зөрчилд холбогдогчдоос төрийн албан хаагч 31, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч-46, төрийн бус байгууллагын ажилтан-5, хувиараа хөдөлмөр эрхлэгч-124, ажилчин малчин-122, оюутан-7, сурагч-2, ажилгүй-161 бусад-129 хүн бүртгэгдсэн байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, зөрчилд холбогдсон нийт 720 хүнийг эрүүлжүүлсэн нь урд оны мөн үеэс 39-өөр буюу 5,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс эмюэгтэй-38, төрийн алба хаагч-17, хувийн хэвшлийн

байгууллагад ажиллагч-34, хувиараа хөдөлмөр эрхлэгч-26, төрийн бус байгууллагын ажилтан-4, малчин-54, оюутан-9, ажилгүй-535, бусад-40 хүн байна.

Мөн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 720 хүнийг эрүүлжүүлсний 38 буюу 5.2 хувь эмэгтэй байна.

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТАСАГ

Зургаа: Дүгнэлт

1. Гэмт хэрэг 2018 онд өссөн шалтгаан нь 2018 оны 12 сард аймгийн Прокурорын газраас 15 насанд хүрээгүй охид хүүхэд төрүүлсэн, үр хөндүүлсэн гэх гомдол мэдээллийг шалгуулахаар албан бичиг ирүүлсэний дагуу хэрэг бүртгэлтийн 7 хэрэг нээсэн мөн шинэ жилийн баяртай холбогдуулан иргэд архидан согтуурч улмаар хоорондоо зодолдож хүний биед хохирол учруулах гэмт хэргийн гаралт өссөнтэй холбоотой. Сард дунджаар 15-20 хэрэг мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэж байсан бол энэ оны 12 сард 28 хэрэг бүртгэгдсэн байна.

2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус аймагт 91 бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 51 хувийг эзэлж байна. Энэ онд тус аймгийн хэмжээнд архидан согтуурсны улмаас хүний эрүүл мэндэд хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэлийн шалтгаантай гэр бүл, найз нөхөд, төрөл садангийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэг зонхилон бүртгэгдсэн.

3. Сүүлийн 3 жилд бүртгэгдээгүй авилгын гэмт хэрэг 6, мансууруулах эм сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 1, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь онцлог байна.

4. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах, мал хулгайлах, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэргүүд 2 нэгжээс 45 хувиар тус тус буурсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсантай холбоотой.

5. Бүртгэгдсэн хүнийг алах гэмт хэргийн шалтгаан нь ахуйн хүрээний архидалт, төрөл садан, найз нөхдийн хүрээний хэрүүл маргаантай холбоотой байна.

Долоо: Санал

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийг бууруулах чиглэлд илүү анхаарах. Ялангуяа согтуугаар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн дийлэнх нь тухайн төрлийн гэмт хэрэг байх тул архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах.

2. Хулгайлах гэмт хэрэг, ялангуяа автотээврийн хэрэгслийн хулгайгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хөршийн холбоо, телекамерын хяналтыг сайжруулах, иргэдийг сонор сэрэмжтэй байх талаар санамж зөвлөмж сэрэмжлүүлгийн хуудсыг тодорхой объектод байршуулах, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах